

“ХОРГО ХАЙРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 04 дүгээр
сарын 27-ний өдөр

Улаанбаатар
хот

“Хорго Хайрхан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн заалтууд, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны 244 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам” болон холбогдох хууль тогтоомжийн дагуу 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдөр “Хорго Хайрхан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс зарлан хуралдуулах шийдвэрийг гаргаж, 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 10:30 минутаас Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамжинд байрлах “Монгол даатгал” ХХК байр, 3 давхарт хурлын танхимд хувьцаа эзэмшигчдийг бүртгэж эхэлсэн ба хурал 11:00 минутанд эхлэв.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга Э.Төгөлдөрийн танилцуулснаар:

“Хорго Хайрхан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын эрхтэй 110,018 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 81,42 хувийг төлөөлсөн 2 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн тул “Компанийн тухай хууль”-ийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид:

Саналын эрх бүхий хувьцааны 81,35 хувийн хувьцаа эзэмшигч болох “Монгол Даатгал” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Батбаяр; саналын эрх бүхий хувьцааны 0,07 хувийн хувьцаа эзэмшигч болох “Би Ди Сек” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Долгормаа нар хуралд оролцсон.

Хурал даргалагч Ц. Ганчимэг ээлжит хурлыг нээж, ээлжит хурал хуралдуулах тухай “Хорго Хайрхан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн №1 тоот тогтоолыг товч танилцуулав.

Хурал даргалагч Ц. Ганчимэг ээлжит хурлын дэгийг танилцуулав.

	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Шийдвэрийн төсөл	Хариуцах эзэн
1.	Хурлын ирцийг бүртгэх, саналын хуудас тараах	10:30-10:50		Хурал зохион байгуулах комисс
2.	Хурлын ирцийг мэдээллэх	10:55-11:00	Тооллогын комиссын тогтоол	Тооллогын комисс
3.	Хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	11:00-11:10	ХЭХ-ын тогтоол	Хурлын дарга Ц.Ганчимэг
4.	Хэлэлцэх асуудал 1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай	11:10-11:25	ХЭХ-ын тогтоол	Хурлын дарга Ц.Ганчимэг
5.	Хэлэлцэх асуудал 2. Ногдол ашгийн тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний үндэслэлийг танилцуулах	11:25-11:30		Хурлын дарга Ц.Ганчимэг

6.	Хэлэлцэх асуудал 3. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох	11:30-11:45	ХЭХ-ын тогтоол	Хурлын дарга Ц.Ганчимэг
7.	Хэлэлцэх асуудал 4. Компанид “Монгол Даатгал” ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрөх, нэгтгэх замаар өөрчлөн байгуулах гэрээ, журмыг батлах тухай	11:45-12:10	ХЭХ-ын тогтоол	Хурлын дарга Ц.Ганчимэг
8.	Хэлэлцэх асуудал 5. Компанид “Монгол Даатгал” ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх тухай	12:10-12:25	ХЭХ-ын тогтоол	Хурлын дарга Ц.Ганчимэг
9.	Хэлэлцэх асуудал 6. Нэгтгэхтэй холбогдуулан хувьцаа хөрвүүлэх, нэмж хувьцаа гаргах тухай	12:25-12:30	ХЭХ-ын тогтоол	Хурлын дарга Ц.Ганчимэг
10.	Хэлэлцэх асуудал 7. МХБ-ийн бүртгэлийн шалгуурыг хангах зорилгоор нэмж хувьцаа гаргах тухай	12:30-12:45	ХЭХ-ын тогтоол	Хурлын дарга Ц.Ганчимэг
11.	Хэлэлцэх асуудал 8. Нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэх тухай	12:45-13:00	ХЭХ-ын тогтоол	Хурлын дарга Ц.Ганчимэг
12.	Хэлэлцэх асуудал 9. Зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах асуудлыг шийдвэрлэх эрхийг ТУЗ-д олгох тухай;	13:00-13:10	ХЭХ-ын тогтоол	Хурлын дарга Ц.Ганчимэг
13.	Хэлэлцэх асуудал 10. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай.	13:10-13:25	ХЭХ-ын тогтоол	Хурлын дарга Ц.Ганчимэг
14.	Санал, асуулт хариулт	13:25-13:35		
	Саналын хуудас бөглөх санамж өгөх	13:35-13:40		Тооллогын комисс
15.	Саналын хуудас бөглөх	13:40-13:50		
	Санал тоолох ажиллагаа	13:50-14:20		Тооллогын комисс
17.	Тооллогын комиссын дарга санал хураалтын дүнг танилцуулах	14:20-14:25		Тооллогын комисс
18.	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	14:25-14:30	ХЭХ-ын тогтоол	Хурлын дарга Ц.Ганчимэг
19.	Хурлыг хаах (хурлын дарга)	14:30-14:40		Хурлын дарга Ц.Ганчимэг

Хурлын дэгийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100%-ийн саналаар батлав.

Хурал даргалагч Ц.Ганчимэг хүрэлцэн ирсэн хүмүүсийг танилцуулав: Энэ өдрийн мэндийг та бүхэнд хүргэе. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн хүмүүсийг танилцуулья: өөрөөсөө эхлэн танилцуулья. Намайг Ц. Ганчимэг гэдэг, “Хорго Хайрхан” ХК-ийн ТУЗ-ийн дарга. Дараагийн хүн бол Ч. Энх-Амгалан “Хорго Хайрхан” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн бөгөөд Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Б.Аюуш, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Ц.Мандулай, “Гендекс ҮЦК” ХХК-ийн Э.Төгөлдөр, Д.Сайнбаяр, “Монгол Даатгал” ХХК-н ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Мөрөн нар оролцов.

Хурлаар хэлэлцэх асуудлуудын материалыг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Бидний хэлэлцэх эхний асуудал бол “Хорго Хайрхан” ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт батлуулах тухай. 2017 онд “Монгол Даатгал” ХХК нь “Хорго Хайрхан” ХК-ийн хувьцааг худалдан авснаар компанийн өмнөх ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагаас компанитай холбоотой баримт бичиг, тамга тэмдэг, холбогдох эд хөрөнгө зэргийг хүлээн авсан боловч уг компани нь 2000-аад оноос хойш үйл ажиллагаагаа явуулаагүй учир зарим бичиг баримт алдагдсан, бичиг баримтын архив хөтлөөгүй, хадгалагдаагүй байна. Иймд Төв аймгийн

Эрдэнэсант сумын засаг дарга болон Төв аймгийн улсын бүртгэлийн хэлтсээс зарим бичиг баримтыг дахин гаргуулсан болно.

“Монгол Даатгал” ХХК нь 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдөр “Хорго Хайрхан” ХК-ийн нийт энгийн хувьцааны 81.35%-ийг Монгол Улсын “Компанийн тухай” хуулийн 56.2; 57.1 “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 22.1.1 болон Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны тухай журам”-ыг үндэслэн сайн дурын үндсэн дээр худалдан авсан.

“Монгол Даатгал” ХХК нь Монгол Улсын “Компанийн тухай” хуулийн 57.1, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 22.1.2 болон Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны тухай журам”-ыг үндэслэн “Хорго Хайрхан” ХК-ийн хувьцааг үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр худалдан авах саналыг нэг бүр нь 70 төгрөгөөс доошгүйгээр 2017 оны 04 сарын 12-ны өдрөөс 2017 оны 05 сарын 12-ны өдрийг дуустал гаргасан. Энэ талаар тухай бүр хууль, журмын дагуу СЗХ, МХБ болон “Хорго Хайрхан” ХК-ийн хувьцаа эзэмшигч нарт олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлж, мэдэгдсэн болно.

ТУЗ-ийн үйл ажиллагаа

2017 оны 7 сарын 05-ны өдөр “Хорго Хайрхан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулж ТУЗ-ийн гишүүдийг шинээр томилсон билээ. Ингээд өнгөрсөн оны хийж гүйцэтгэсэн ажлуудаас товч дурдвал:

1. ТУЗ-ийн хурлыг 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдөр хуралдуулж, шинээр ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулж, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмуудыг баталж, “Хорго Хайрхан” ХК-д “Монгол Даатгал” ХХК-ийг нэгтгэх асуудлыг судалж эхэлсэн.

2. ТУЗ-ийн дараагийн хурлаар засаглалыг сайжруулахаар Хувьцаат компанийн эрхэм зүйл болох Компанийн засаглалын кодексыг нэвтрүүлэхээр КЗК-ын холбогдох журмуудыг батлан үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн. Түүнчлэн, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг баталсан.

3. “Хорго Хайрхан” ХК-д “Монгол Даатгал” ХХК-ийг нэгтгэх асуудлаар СЗХ-ны шаардлагын дагуу хөндлөнгийн аудит, үнэлгээ, хуулийн компаниудтай гэрээ байгуулан дүгнэлтүүдийг гаргуулах ажлыг эхлүүлж гаргуулсан.

4. ТУЗ-ийн хурлаар “Хорго Хайрхан” ХК-д “Монгол Даатгал” ХХК-ийг нэгтгэх төсөл, гэрээ, журам, хөрвүүлэх тооцоог хэлэлцэн, бүх гишүүд санал нэгтгэйгээр сайшааж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэхээр болсон.

Эдгээр ажлуудыг хийж гүйцэтгэхэд өмнөх жилүүдийн баримт бичгүүд гээгдсэн, олдсон цөөхөн бичиг баримтууд нь ажлын шаардлага хангахгүй, удаа дараа өмнөх удирдлагуудтай холбогдож бичиг баримтуудыг олох үйл ажиллагаанд нэлээд цаг зарцуулсан гэдгийг дурдах нь зүйтэй болов уу.

ТУЗ-ийн хороодын үйл ажиллагаа

Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргаж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах, Гүйцэтгэх удирдлагыг томилох талаар баримтлах бодлогыг тодорхойлох асуудлаар хуралдаж холбогдох ажлуудыг хийж ажиллаа.

Цалин урамшууллын хороо нь Хувьцаат компаниудын ТУЗ-ийн цалин урамшууллын бодлогыг судалж холбогдох журмыг баталлаа. “Хорго Хайрхан” ХК нь 2017 онд үйл ажиллагаа явуулаагүй тул одоогоор ТУЗ-ийн төсөв, цалин урамшууллыг хэрэгжүүлэх боломжгүй байна.

Аудитын хороо нь Компанийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланг аудитаар хянуулж, компанийн хөрөнгийг дахин үнэлүүлж, 2011 оны хөрөнгийн өөрчлөлтийг балансаас хасч компанийн санхүүгийн үзүүлэлтийг цэгцэллээ.

Хурлын дарга Ц.Ганчимэг: Хоёр дахь хэлэлцэх асуудал бол ногдол ашгийн тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний үндэслэлийг танилцуулах байна.

Та бүхний мэдэж байгаагаар “Хорго Хайрхан” ХК өнөөг хүртэл идэвхитэй үйл ажиллагаа явуулаагүй, аливаа нэгэн орлого, ашиг байхгүй байгаа тул ТУЗ-ийн 2018 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн №1 тоот тогтоолоор санхүү эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан 2017 оны үйл ажиллагааны ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

Хурлын дарга Ц.Ганчимэг: Гурав дахь хэлэлцэх асуудал бол Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудал байна. Шинээр томилогдох ТУЗ-ийн гишүүд маань Компанийн засаглалын кодексийн дагуу компанийн засаглалын болон ТУЗ-ийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан сургалтанд хамрагдан компанийн тухай хуулийн 75.8 дах заалтыг хангасан мэдлэг туршлагатай хүмүүс байгаа. Хурлын танилцуулгад эдгээр хүмүүсийн мэдлэг боловсрол, ажил эрхлэлтийн талаарх мэдээллийг оруулсан бөгөөд бүгд ажлын туршлагатай, санхүү, хууль, үнэт цаасны зах зээлийн мэдлэгтэй салбар бүртээ мэргэшсэн, компанийн засаглалын гэрчилгээтэй хүмүүс болно.

Хурлын дарга Ц.Ганчимэг: 4, 5, 6, 7, 8, 9 дэх хэлэлцэх асуудал бол Компанид “Монгол Даатгал” ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрөх, нэгтгэх замаар өөрчлөн байгуулах гэрээ, журмыг батлах тухай; Компанид “Монгол Даатгал” ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх тухай; Нэгтгэхтэй холбогдуулан хувьцаа хөрвүүлэх, нэмж хувьцаа гаргах тухай; МХБ-ийн бүртгэлийн шалгуурыг хангах зорилгоор нэмж хувьцаа гаргах тухай; Нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэх тухай; Зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах асуудлыг шийдвэрлэх эрхийг ТУЗ-д олгох тухай асуудлууд тус тус байна. Эдгээр асуудлууд өргөн цар хүрээтэй, нэг нь нөгөөтэйгөө уялдаатай багц асуудлууд болно. Энэ талаар Профессор Б. Аюуш гуай та бүхэнд дэлгэрэнгүй мэдээллийг одоо өгнө.

Б.Аюуш: Ер нь бол энэ хурал ээлжит хурал тийм учир үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлыг заавал хэлэлцэх ёстой байдаг. За энэ асуудлыг хэлэлцлээ сая. Саналын хуудсаараа шийдвэрээ гаргана. Өнөөдрийн хурлын гол онцлог бол компанид “Монгол Даатгал”

компанийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах асуудал байгаа. Энэ асуудлын гол ач холбогдол, зорилго юу юм бэ гэхээр “Монгол Даатгал” гээд даатгалын зах зээл дээр 90 гаруй жил үйл ажиллагаа явуулсан хамгийн анхны даатгалын компани. Даатгалын зах зээлийн 20 гаруй хувийг дангаараа эзэлдэг ийм том компанийг хувьцаат компани болгож хөрөнгийн биржд бүртгэлтэй болгох хамгийн хялбар дөт зам учраас энэ асуудлыг шийдвэрлэх бол энэ өдрийн хамгийн гол зорилго байгаа. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд энэ өөрчлөн байгуулагдаж байгаа хоёр компани хоорондоо нэгтгэх гэрээ гэж байгуулах ёстой. Энэ гэрээг үндэслээд нэгтгэх ажиллагааг яаж хэрэгжүүлэх вэ гэдэг журам гээд ийм үндсэн хоёр бичиг баримтыг батлах ийм асуудал байгаа. За, дараа нь бол Хөрөнгийн биржд бүртгэлтэй компани болж байгаа учраас хөрөнгийн биржийн бүртгэлийн шалгуур шаардлагыг хангах гэдэг бас нэг асуудал үүсэж гарч ирдэг. Тэр нь юу вэ гэхээр Хөрөнгийн бирж бол нийт бүртгэгдсэн хувьцааныхаа 20-иос доошгүй хувийг олон нийтэд санал болгон арилжаалах ёстой гэсэн шаардлага байгаа. Тэгэхээр өнөөдөр бол компанийн хувьцааны 80 гаруй хувийг “Монгол Даатгал” компани дангаараа эзэмшидэг. За, энэ компани маань нэгтгэсний дараагаар “Монгол Даатгал”-ын хөрөнгөтэй харьцуулахын бол тооцоогоор 3 дахин олон хувьцаатай байгаа, нэгтгэсний дараагаар нийт хувьцааны бараг 99,99 хувь нь нэг этгээдийн өмчлөлд төвлөрөх байгаа. Энэ нь бол Хөрөнгийн биржийн шалгуур шаардлагыг хангахгүй, ийм учраас нэмэж хувьцаа гаргах тухай асуудлыг бас хэлэлцэх ёстой байгаа. Энэ асуудлыг хэлэлцэхдээ шууд Хороо, Хөрөнгийн биржид нэмж гаргаж байгаа хувьцааг бүртгүүлэхээр өгөх боломж байхгүй. Яагаад гэвэл Үнэт цаасны зах зээлийн тухай хуулинд яг тухайн үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, компанийн байдал, үнэт цаасны тухай асуудлыг тусгасан танилцуулга бэлдэх ёстой. Гэтэл өнөөдөр бид нар танилцуулга бэлдэнэ гэхээр “Хорго Хайрхан” компанийн тухай танилцуулга бэлдэх ёстой болно. Нэгтгэх ажиллагаа яг хэдийд хуулийн дагуу дуусгавар болно гэхэд компанийг нэгтгэх үйл ажиллагааг Хөрөнгийн бирж эхлээд зөвшөөрнө, дараа нь Хороо зөвшөөрөөд, Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт ороод, Улсын бүртгэлд энэ өөрчлөлтийг бүртгүүлсэнээр нэгтгэх ажиллагаа албан ёсоор дуусгавар болно. Энэ ажиллагаа хэрэгжиж дууссаны дараагаар нөхцөл байдал өөр болно, өөрөөр хэлбэл Хөрөнгийн биржд бүртгэлтэй “Монгол Даатгал” гэдэг компани болно. Тэгэхээр энэ “Монгол Даатгал” гэдэг Хөрөнгийн биржд бүртгэлтэй компани маань өөрөө яг ямар компани юм, санхүүгийн байдал юу болсон юм гээд энэ бүх байдлыг тусгасан танилцуулга бэлдэж Хөрөнгийн бирж, Хороонд толилуулсанаар нэмж гаргасан үнэт цаасыг бүртгүүлэх боломжтой болно. Энэ маань өөрөө хэдийгээр бид нар өнөөдөр зөвшөөрч байгаа ч гэсэн цаг хугацааны хувьд ийм асуудал байгаа гэдэгт та бүхний анхаарлыг хандуулахыг хүсч байна. Өнөөдөр бид нар энэ асуудлуудыг хэлэлцэж гэрээг батлана. Гэрээ бол урьдчилсан журмаар хоёр компанийн ТУЗ тохиролцоод гэрээний төслийг баталсан. Төслийг өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулж та бүхнээр батлуулахаар оруулж ирж байгаа. За, энэ гэрээтэй холбоотой хэрэгжүүлэх журмыг бас батлуулна. Тэрнээс гадна мөн үйл ажиллагааны үр дагаварт нэмж гаргасан хувьцааг бүртгүүлэх асуудлыг танилцуулна. Нэмж хувьцаа гаргах тухай шийдвэрийг, нэгэнт компани маань хувьцаат компани болж өөрчлөгдөж байгаа учраас дүрмэнд бол даатгалын үйл ажиллагаа эрхлэдэг ийм компани болж өөрчлөгдөж байгаа учраас дүрмэнд маш их хэмжээний өөрчлөлт орно, тийм учраас дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах ёстой болно. За, мөн компани өөрчлөн байгуулагдсантай холбоотойгоор хувьцаа эзэмшигчид компанид энэ асуудлыг зөвшөөрөөгүй юм уу эсвэл энэ асуудлыг хэлэлцэх энэ өнөөдрийн хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэх худалдахыг шаардах эрх үүсдэг.

За, энэ эрхийг хэрэгжүүлэх журмыг бас батлана. Энэ маань өөрөөр хэлбэл өөрчлөн байгуулахтай холбоотой багц асуудлууд байгаа. Энэ хэлэлцэх асуудлуудын дөрвөөс арав хүртэл асуудлуудыг хамрана. За, энэ бүх асуудлууд та бүхэнд тараасан материал дээр байгаа: яаж өөрчлөх вэ, ямар гэрээний дагуу өөрчлөгдөх гэж байна, дүрмийн шинэчилсэн найрууллагад ямар асуудлыг тусгав, хувьцаагаа эргүүлэн худалдах эрхийг яаж хэрэгжүүлэх вэ гээд энэ бүх асуудлуудыг цогцоор нь та бүхэнд тараасан материалд тусгасан байгаа. Хэрвээ энийг бүгдийг уншиж таницуулна гэвэл дахиад 2 цаг та нарт тараасан байгаа юмийг унших хэрэг гарна, тийм учир би унших шаардлага байхгүй байх аа гэж бодож байна. Та бүхнээс хэрвээ асуулт байвал, тодруулах юм байвал асуугаарай гэж хэлмээр байна. За, энэ дээр хамгийн гол, онцгой анхаарал татах асуудал бол би сая хэлсэн, нэмж хувьцаа гаргах асуудал, гэхдээ нэмж хувьцаа гаргахыг өнөөдөр бид зөвшөөрхөөс өөр арга байхгүй, биржийн шаардлага учраас, гэхдээ бүртгүүлэх тухай асуудал бол зайлшгүй танилцуулгыг шинэчилсэний дараагаар бүртгүүлэх юм шүү гэдгийг бас анхаарулья. Ингээд бүртгүүлсэний дараагаар бас хувьцаа эзэмшигчдэд ямар эрх үүсдэг вэ гэвэл тэргүүн ээлжинд худалдаж авах гэдэг давуу эрх үүсдэг. За, энэ эрхийг бас хэрэгжүүлэх тухай асуудал. Ингээд цогцоороо дөрвөөс аравдугаар асуудал дуустал ийм цогц асуудал байгаа. Та бүхэн энэ тараасан материалтай танилцсан гэж итгэж байна. Танилцсан зүйлээс тодорхойгүй юм уу асууж тодруулах зүйл байвал асууж тодруулж болно, хариулахад бэлэн байна.

Хурлын дарга Ц.Ганчимэг: 10 дахь хэлэлцэх асуудал дээр нэмж хэлэхэд бид компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг Иргэний тухай хууль, Компанийн тухай хууль, Даатгалын тухай багц дүрэм, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж та бүхэнд хүргүүлсэн болно. Та бүхэн үзэж танилцсан гэж бодож байна. Ажлын явцад дээр дурьдсан хуулиудад зохицуулан нэмэлт зарим заалтууд орсон бөгөөд та бүхэнд хурлын эхэнд тарааж өгсөн дүрмийн төсөлд нэмэлтээр орсон өөрчлөлтүүдийн тодруулж доогуур нь зурсан байгаа тул та бүхэн уншиж танилцаад, санал хүсэлтээ хэлнэ үү.

Хурлын дарга Ц.Ганчимэг: Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул санал хураалтаа явуулах уу.

Хувьцаа эзэмшигч нарт санал өгөх хуудсанд санал өгөх журмыг тооллогын комиссын дарга Э.Төгөлдөр танилцуулав.

Тооллогын комиссын дарга Э.Төгөлдөр: Хувьцаа эзэмшигчид санал өгөх журмыг тайлбарлав.

Тооллогын комисс саналын хайрцаг хоосон, битүүмжилсэн болохыг хуралд оролцогчдод үзүүлэв. Улмаар хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар саналаа өгцгөөв. Дараа нь тооллогын комисс санал тоолох ажилдаа орж, хуралд тооллогын дүнг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Э.Төгөлдөр: Санал хураалтын үр дүнд үндэслэн Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Хэлэлцсэн асуудлын дагуу саналын хуудсаар санал авч дараах үр дүнд хүрлээ.

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 110,018 ширхэг хувьцаа эзэмшдэг 2 хувьцаа эзэмшигчид биеэр оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий энгийн

хувьцаа болох 135,126.00 ширхэг энгийн хувьцааны 81,42% болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.

2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн заалт, компанийн дүрмийн 7.1.4 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 81,42%-ийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.
3. Хурлын ирц хангалттай тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хурлын дэгийн дагуу явуулахыг зөвшөөрсүгэй.
4. “Хорго Хайрхан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцсэн асуудлаар санал өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналыг танилцуулахад:
 - “Хорго Хайрхан” ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах асуудлыг хуралд оролцсон нийт саналын эрхтэй хувьцааны 100 хувийн саналаар зөвшөөрсөн;
 - Компанид “Монгол Даатгал” ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрөх, нэгтгэх замаар өөрчлөн байгуулах гэрээ, журмыг батлах тухай асуудлыг хуралд оролцсон нийт саналын эрхтэй хувьцааны 100 хувийн саналаар зөвшөөрсөн;
 - Компанид “Монгол Даатгал” ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх тухай асуудлыг хуралд оролцсон нийт саналын эрхтэй хувьцааны 100 хувийн саналаар зөвшөөрсөн;
 - Нэгтгэхтэй холбогдуулан хувьцаа хөрвүүлэх, нэмж хувьцаа гаргах тухай асуудлыг хуралд оролцсон нийт саналын эрхтэй хувьцааны 100 хувийн саналаар зөвшөөрсөн;
 - МХБ-ийн бүртгэлийн шалгуурыг хангах зорилгоор нэмж хувьцаа гаргах тухай асуудлыг хуралд оролцсон нийт саналын эрхтэй хувьцааны 100 хувийн саналаар зөвшөөрсөн;
 - Нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэх тухай асуудлыг хуралд оролцсон нийт саналын эрхтэй хувьцааны 100 хувийн саналаар зөвшөөрсөн;
 - Зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах асуудлыг шийдвэрлэх эрхийг ТУЗ-д олгох тухай асуудлыг хуралд оролцсон нийт саналын эрхтэй хувьцааны 100 хувийн саналаар зөвшөөрсөн;
 - Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай асуудлыг хуралд оролцсон нийт саналын эрхтэй хувьцааны 100 хувийн саналаар зөвшөөрсөн;
5. Компанийн тухай хуулийн 62.1.7 заалт, тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн “Хорго Хайрхан” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь**:
Компанийн “Хорго Хайрхан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай. Үүнд:

1. Ц.Ганчимэг
2. Т.Батзул
3. Д.Мөнхбат
4. М.Чингүүн
5. Я. Энхбаяр
6. Ч. Энх-Амгалан

ТУЗ-ийн хараат бус гишүүнээр:

1. Ц. Цэндмаа
2. Б.Аюуш

3. Ц. Мандулай

Хурлын дарга Ц.Ганчимэг: Тооллогын комисс шийдвэрээ танилцууллаа. Үүнийг үндэслэн хурлаас гарах шийдвэрүүдийг танилцуулахад:

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх зүйл, “Хорго Хайрхан” ХК-ийн 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- I. Компанийн 2017 оны жилийн эцсийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлан өгсөн. Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч, баталсугай.
- II. “Хорго Хайрхан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд кумулятив санал хураалтын аргаар олонхийн санал авсан

1. Ц. Ганчимэг
2. Т. Батзул
3. Д. Мөнхбат
4. М. Чингүүн
5. Я. Энхбаяр
6. Ч. Энх-Амгалан нарыг;

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд кумулятив санал хураалтын аргаар олонхийн санал авсан

1. Ц. Цэндмаа
2. Б. Аюуш
3. Ц. Мандулай нарыг тус тус сонгосугай.

III. Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 4; 17; 18; 20; 38; 53; 54; 62; 87; 88; 89; 92, “Иргэний хууль”-ийн 31 дүгээр зүйлийн холбогдох заалтууд, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 3.1. дэх хэсэг, 5.3. дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2018 оны 2018/01 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон “Хорго Хайрхан” ХК-ийн 2018 оны 04 дүгээр сарын 27-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанид “Монгол Даатгал” ХХК-ийг нэгтгэж, түүний эрх үүрэг, хариуцлагыг “Хорго Хайрхан” ХК-д шилжүүлэн өөрчлөн зохион байгуулсугай.
2. Нэгдэж буй “Монгол Даатгал” компанийн оноосон нэрийг өөрчлөн байгуулагдсан компанид үргэлжлүүлэн хэрэглэхийг зөвшөөрч, “Хорго Хайрхан” ХК-ийн оноосон нэрийг “Монгол Даатгал” ХК болгохыг зөвшөөрсүгэй.
3. Компанийг нэгтгэх үйл ажиллагаатай холбогдуулан дараах баримт бичгийг энэ тогтоолын хавсралтаар тус тус баталсугай. Үүнд:

- 3.1. “Хорго Хайрхан” ХК-д “Монгол Даатгал” ХХК-ийг нэгтгэх гэрээ /Хавсралт №1/;
 - 3.2. “Хорго Хайрхан” ХК-д “Монгол Даатгал” ХХК-ийг нэгтгэх журам /Хавсралт №2/;
 - 3.3. “Хорго Хайрхан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх тухай журам” /Хавсралт №3/
4. Компанийг нэгтгэх замаар өөрчлөн зохион байгуулах үйл ажиллагаатай холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж буй дараах асуудлуудыг дэмжиж, зөвшөөрсүгэй.
 - 4.1. Нэгдэж байгаа “Монгол Даатгал” ХХК-ийн хувьцааг “Хорго Хайрхан” ХК-ийн хувьцаанд 3.214 харьцаагаар хөрвүүлж, 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 113,764,962 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган “Монгол Даатгал” ХХК-ийн 100 хувийн хувьцаа эзэмшигч “Миллениум Секюритис Менежмент Лимитед” ХХК-д эзэмшүүлэх;
 - 4.2. Биржийн бүртгэлийн шалгуур хангах зорилгоор нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 37,831,570 ширхэг хувьцаа нэмж гаргах;
 - 4.3. Нэмж гаргасан хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдаж авах эрхийг эдлүүлэх;
 5. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг /Хавсралт №4/-аар баталсугай.
 6. Компанийн зарласан хувьцааны тоог нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 151,866,784 ширхгээр шинэчлэн тогтоож, дүрэмд тусгасугай.
 7. Зарласан боловч гаргаагүй 37,831,570 ширхэг хувьцааг гүйлгээнд гаргах, санал болгох үнийг тогтоох эрхийг ТУЗ-д олгосугай.
 8. Энэ тогтоолын 7-д заасан эрхийг хэрэгжүүлэхийн тулд ҮЦЗЗ-ийн тухай хуулийн 10.12 болон 10.13-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.
 9. Нэгтгэх үйл ажиллагааны хүрээнд компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах болон бүртгүүлэх, хадгалуулах, компанийн шинэчилсэн бүртгэлийг Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ч.Энх-Амгалан/-д, даатгагчийн эрх зүйн байдал, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл авахыг “Монгол Даатгал” ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Т.Батзул/-д тус тус даалгасугай.
 10. ХК-д нэгдэж, эрх үүрэг хариуцлагыг бүрэн шилжүүлж, дуусгалтын тайланг гаргасан “Монгол Даатгал” ХХК-ийг татан буулгаж, Улсын бүртгэлээс хасуулахыг “Монгол Даатгал” ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Т.Батзул/-д үүрэг болгосугай.

Хурлын дарга Ц.Ганчимэг: Хурал хаасныг мэдэгдэв.

Хурал 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 12 цаг 50 минутад өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Д. САЙНБАЯР

ХУРЛЫН ДАРГА:

Ц.ГАНЧИМЭГ